



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 9/62

Мандалговь


“ИНЖ КАД” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 36,000,000 (гучин зургаан сая) төгрөг, Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслөөс 84,000,000 (наян дөрвөн сая) төгрөгийн хөрөнгөөр “Хүнсний ногооны зоорь шинээр барих” ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажилд ирүүлсэн үнийн саналаар шалгарсан “Инж кад” ХХК-тай 9,989,000 (есөн сая есөн зуун наян есөн мянга) төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу “Хүнсний ногооны зоорь шинээр барих” зураг, төсвийн боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Инж кад” ХХК-ны захирал (Б.Оюун)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.



485210081